

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Удирдлагын академийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй
тайлан

Аудитын код: СНАГ-2025/020/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер:В.Эрдэнэцогт Утас:260512 Цахим хаяг: erdenetsogtb@audit.gov.mn Аудитор: Г.Ганбилэг Утас:261740 Цахим хаяг: ganbilegg@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Лидер экаунт аудит” ХХК-ийн захирал:П.Шаравхорол Утас:88472789 Цахим хаяг: leaderaudit.20@gmail.com
--	---



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.16 № 07/1511
танай _____-ны № _____-г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Удирдлагын академийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал: Ашиглалтад бүрэн ороогүй программ хангамжийг орлогоор бүртгэсэн, ажилчид олгох урамшуулал, цалин хөлсийг буруу тооцож олгосон, дээд шатны байгууллагын шийдвэргүй цалин, хөлсийг нэмэгдүүлсэн, худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгосон, үр ашиггүй зардал гаргасан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 778.5 сая төгрөгөөр давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.1.1, 32 дугаар зүйлийн 32.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.6.2, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.10, 24 дүгээр зүйлийн 24.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.9, 4.2.1, 4.2.3, 10 дугаар зүйлийн 10.2, 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.2.6 дахь заалтуудтай нийцээгүй.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хянасан Удирдлагын академийн 2024 оны санхүүгийн төлөвлөгөөнд Удирдлагын академийн 100 жилийн ойн арга хэмжээний

зардалд 1,200.0 сая төгрөг, нэмэлт төсвөөр академийн барилга, орчны засвар үйлчилгээ, машин, тоног төхөөрөмж худалдан авах зэрэг зардалд 2,038.2 сая төгрөг, нийт 3,238.2 сая төгрөгийн төсөв баталжээ. Гүйцэтгэлээр 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд 2,267.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын 2022 оны 139 дүгээр тогтоолоор 2023 оноос эхлэн Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх” богино хугацааны сургалтыг нэмж тусгахтай холбогдуулан 934.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудал

Засгийн газрын 2022 оны 438 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат болох “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулахад Засгийн газрын нөөц сангаас 416.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,138,593,371.77	13,155,135,862.50
31	Мөнгө хөрөнгө	14,104,889,683.83	12,609,312,609.22
311	Кассад байгаа бэлэн мөнгө	1,173,830.00	751,150.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	6,772,917,205.88	5,099,886,527.70
315	Банканд байгаа хадгаламж	7,330,798,647.95	7,508,674,931.52
33	Авлага	662,024,513.60	153,177,394.68
33100	Ажиллагсадтай холбоотой авлага	1,059,724.95	-
335	Бусад авлага/байгууллагаас авах авлага/	660,964,788.65	153,177,394.68
34	Урьдчилгаа	268,049,309.00	59,590,052.00
3471	Урьдчилгаа тооцоо	261,299,500.00	59,590,052.00
3472	Урьдчилж төлсөн зардал	6,749,809.00	-
35	Бараа материал	103,629,865.34	333,055,806.60
351	Түүхий эд материал	14,684,020.00	48,601,670.00
352	Бараа	16,595,540.00	10,856,840.00
354	Хангамжийн материал	72,350,305.34	273,597,296.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,644,147,470.07	8,015,318,528.93
392	Биет хөрөнгө	6,737,153,114.99	6,031,124,334.63
39201	Барилга байгууламж	6,066,097,840.81	6,066,097,840.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,377,139,415.75)	(1,884,989,532.47)
39203	Авто тээврийн хэрэгсэл	54,780,000.00	130,680,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(54,780,000.00)	(54,780,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж	2,321,988,742.00	2,504,097,491.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,240,705,171.18)	(1,669,302,061.98)
39207	Тавилга аж ахуйн эд хогшил	1,239,650,783.00	1,301,603,307.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(592,732,289.22)	(723,250,049.57)
39217	Ном	227,091,718.18	241,238,354.18
39218	Бусад үндсэн хөрөнгө	186,866,138.80	235,997,570.80
39218	Хуримтлагдсан элэгдэл	(93,965,231.65)	(116,268,585.90)
393	Биет бус хөрөнгө	1,906,994,355.08	1,984,194,194.30
39301	Программ хангамж	276,870,208.00	545,521,708.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(143,216,152.92)	(224,315,393.70)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,289,036,300.00	2,182,862,280.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(515,696,000.00)	(519,874,400.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	23,782,740,841.84	21,170,454,391.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,778,761,182.30	1,328,859,107.87
41	Богино хугацаат өр төлбөр	2,778,761,182.30	1,328,859,107.87
4136	Бусад өглөг	87,370,242.30	108,133,755.50
41361	Байгууллагад өгөх өглөг	60,635,905.80	75,117,276.70
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	26,734,336.50	33,016,478.80
414	Урьдчилж орсон орлого	2,691,390,940.00	1,220,725,352.37
41420	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	1,693,462,940.00	341,896,121.00
41421	Бусад урьдчилж орсон орлого	997,928,000.00	878,829,231.37
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	21,003,979,659.54	19,841,595,283.56
51	Засгийн газрын хувь оролцоо	3,922,018,782.44	3,815,844,762.44
51101	Өмч:Төрийн	3,922,018,782.44	3,815,844,762.44
512	Хуримтлагдсан үр дүн	13,620,050,048.46	12,563,839,692.48
51210	Өмнөх үеийн үр дүн	11,469,447,514.23	13,620,296,048.46
51220	Тайлант үеийн үр дүн	2,150,602,534.23	(1,056,456,355.98)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,461,910,828.64	3,461,910,828.64
6	ӨР ТӨЛБӨР, ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	23,782,740,841.84	21,170,454,391.43

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛААГААНЫ ОРЛОГЫН ДҮН	12,608,346,670.98	12,973,521,287.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,653,525,810.98	5,961,553,937.57
120	Нийтлэг татварын бус орлого	5,653,525,810.98	5,961,553,937.57
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,653,525,810.98	5,961,553,937.57
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,738,565,978.00	3,218,682,986.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,629,689,221.58	749,080,829.61
1200044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	285,270,611.40	111,413,870.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	48,658,532.76
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	38,658,432.76
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	10,000,100.00
120009	Бусад орлого	-	1,833,717,719.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,954,820,860.00	7,011,967,350.00
1310	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,881,214,660.00	7,011,967,350.00
131001	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	2,073,606,200.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛААГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,461,263,017.66	14,029,977,643.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,461,263,017.66	14,029,977,643.55
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	10,320,748,637.66	13,820,142,544.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,702,633,870.18	5,860,772,879.93
210101	Цалин	3,395,214,629.08	3,059,953,410.10
210102	Нэмэгдэл цалин	-	748,803,284.39
210105	Гэрээт ажлын хөлс	171,942,310.00	1,523,177,461.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	135,476,931.10	250,103,523.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	459,442,526.50	610,409,529.06
210201	Тэтгэврийн даатгал	459,442,526.50	610,409,529.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	267,564,165.50	262,134,125.65
210301	Гэрэл, цахилгаан	116,235,365.50	106,534,164.00
210302	Түлш, халаалт	117,950,900.00	119,053,060.60
210303	Цэвэр, бохир ус	33,377,900.00	36,546,901.05
2104	Хангамж, бараа материалын зардал	139,445,976.09	287,291,569.56
210401	Бичиг хэргийн материал	46,214,671.49	149,294,268.87
210402	Тээвэр, шатахууны зардал	8,282,595.00	12,973,667.92
210403	Шуудан, холбооны зардал	35,821,082.00	61,620,315.77
210404	Ном, хэвлэлийн зардал	5,226,778.00	17,520,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,657,990.00	11,210,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,242,859.00	19,844,112.00
210407	Аж ахуйн материал авах зардал	-	14,828,905.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	87,476,210.00	671,001,470.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,067,110.00	2,025,409.00
210602	Урсгал зардал	81,409,100.00	668,976,061.00
2107	Томилолт, зочны зардал	70,182,190.00	114,374,024.50
210701	Гадаад албан томилолт	42,619,885.00	71,309,706.50
210702	Дотоод албан томилолт	8,215,600.00	26,913,645.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	19,346,705.00	16,150,673.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,010,843,274.87	2,514,893,688.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	998,292,023.87	2,353,581,485.09
210803	Харуул, хамгаалалтын зардал	114,990,000.00	148,520,000.00

Удирдлагын академийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

210802	Аудитын төлбөр	12,000,000.00	12,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	551,251.00	792,203.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,583,160,424.52	3,499,265,257.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,411,200.00	286,505,702.18
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,642,418,776.69	2,037,967,792.81
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	928,330,447.83	1,174,791,762.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,514,380.00	209,835,098.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	140,514,380.00	209,835,098.87
213207	Тэтгэвэрт гарахад нэг удаагийн тусламж	41,823,000.00	41,291,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	98,691,380.00	91,614,698.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	2,147,083,653.32	(1,056,456,355.98)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	3,518,880.91	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	3,518,880.91	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	2,150,602,534.23	(1,056,456,355.98)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	3,922,018,782.44	3,461,910,828.64	11,469,447,514.23	18,853,377,125.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт алдаа	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,922,018,782.44	3,461,910,828.64	11,469,447,514.23	18,853,377,125.31
Тайлангийн үеийн үр дүн			2,150,602,534.23	2,150,602,534.23
2023 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	3,922,018,782.44	3,461,910,828.64	13,620,050,048.46	21,003,979,659.54
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(106,174,020.00)		246,000.00	(105,928,020.00)
Тайлангийн үеийн үр дүн	-	-	(1,056,456,355.98)	(1,056,456,355.98)
2024 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	3,815,844,762.44	3,461,910,828.64	12,563,839,692.48	19,841,595,283.56

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛААГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	13,583,872,964.28	12,057,998,359.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,935,589,164.28	5,046,031,009.70
120004	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	4,935,364,334.28	5,046,031,009.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,637,969,378.00	3,063,386,693.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,297,394,956.28	1,871,230,446.70
120009	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	224,830.00	111,413,870.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,648,283,800.00	7,011,967,350.00
1310	Улсын төсвөөс	8,648,283,800.00	7,011,967,350.00
131001	Урсгал санхүүжилт	4,881,214,660.00	7,011,967,350.00
131006	Бусад тусгай зориулалтын сангаас-ЗГ-ын нөөц сан	2,490,421,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛААГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	9,468,367,983.23	13,184,518,525.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,468,367,983.23	13,184,518,525.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,327,853,603.23	12,978,727,926.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,677,410,258.31	5,878,048,047.34
210101	Цалин	3,370,893,505.50	3,059,913,410.10
210102	Нэмэгдэл	-	748,623,284.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	135,476,931.10	250,103,523.59
210204	Урамшуулал	-	278,735,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	171,039,821.71	1,540,672,629.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	459,732,063.97	610,354,118.52
210201	Тэтгэврийн даатгал	459,732,063.97	610,354,118.62
2103	Тогтмол зардал	268,054,165.50	261,829,277.65
210301	Гэрэл, цахилгаан	116,235,365.50	106,534,164.00
210302	Түлш, халаалт	117,950,900.00	119,053,060.60
210303	Цэвэр, бохир ус	33,867,900.00	36,242,053.05
2104	Хангамж, бараа материалын зардал	112,564,445.25	445,661,300.70
210401	Бичиг хэргийн материал	27,824,934.65	74,299,472.91
210402	Тээвэр, шатахууны зардал	8,300,000.00	15,098,564.00
210403	Шуудан, холбооны зардал	36,708,622.00	55,897,263.77
210404	Ном, хэвлэлийн зардал	5,461,508.60	138,896,927.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,657,990.00	13,025,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,611,390.00	148,444,073.02
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,656,354.00	751,887,998.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,268,920.00	35,229,324.00
210604	Урсгал зардал	36,387,434.00	716,658,674.00
2107	Томилолт, зочны зардал	70,182,190.00	114,413,348.50
210701	Гадаад албан томилолт	42,619,885.00	71,105,906.50
210702	Дотоод албан томилолт	8,215,600.00	26,357,929.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	19,346,705.00	16,949,513.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	989,066,954.39	2,460,311,831.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	976,515,703.39	2,460,311,831.03
210802	Аудитын төлбөр	12,000,000.00	12,000,000.00
210803	Тээврийн хэрэгслийн татвар	551,251.00	1,053,023.00
210506	Мэдээлэл технологийн үйлчилгээ	-	26,273,709.82
210808	Бусад үйлчилгээний хураамж	-	652,149.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,705,187,171.81	2,456,222,004.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,441,200.00	276,179,062.66
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,692,775,971.81	2,180,042,941.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,514,380.00	205,790,598.87

Удирдлагын академийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	140,514,380.00	205,790,598.87
213207	Тэтгэвэрт гарахад нэг удаагийн тусламж	41,823,000.00	42,887,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	98,691,380.00	71,288,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4,115,504,981.05	(1,126,520,165.61)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,238,894,906.00	369,056,909.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,238,894,906.00	369,056,909.00
225106	Биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,238,894,906.00	369,056,909.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,238,894,906.00)	(369,056,909.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО ГҮЙЛГЭЭ	3,518,880.91	-
14	Бусад эх үүсвэр	3,518,880.91	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	3,518,880.91	-
8	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,518,880.91	-
9	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,880,128,955.96	(1,495,577,074.61)
10	Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,224,760,727.87	14,104,889,683.83
11	Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,104,889,683.83	12,609,312,609.22

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023 оы гүйцэтгэл	2024 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	10,707,262,889.23	16,891,553,200.00	13,553,575,434.31	3,337,977,765.69	80.2
Нийт зарлагын дүн	10,707,262,889.23	16,891,553,200.00	13,553,575,434.31	3,337,977,765.69	80.2
Урсгал зардлын дүн	10,707,262,889.23	16,879,449,418.52	13,553,575,434.31	3,337,977,765.69	80.3
Бараа ажил үйлчилгээний зардал	10,566,748,509.23	14,526,122,418.52	13,347,784,835.44	1,190,441,364.56	91.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,677,410,258.31	6,312,660,000.00	5,878,048,047.34	434,611,952.66	93.1
Цалин	3,370,893,505.50	5,600,000,000.00	3,808,536,697.49	3,808,536,697.49	68.0
Унаа хоолны хөнгөлөлт	135,476,931.10	308,660,000.00	250,103,523.59	58,556,476.41	81.0
Урамшуулал	-	260,000,000.00	278,735,200.00	(18,735,200.00)	107.2
Гэрээт ажлын хөлс	171,039,821.71	144,000,000.00	1,540,672,629.26	(1,396,672,629.26)	1,069.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	459,732,063.97	720,354,118.52	610,354,118.52	110,103,781.48	84.7
Тэтгэврийн даатгал	459,732,063.97	720,354,118.52	610,354,118.52	110,103,781.48	84.7
Тогтмол зардал	268,054,165.50	285,854,900.00	261,829,277.65	24,025,622.35	91.6
Гэрэл, цахилгаан	116,235,365.50	120,190,700.00	106,534,164.00	13,656,536.00	88.6
Түлш, халаалт	117,950,900.00	119,266,500.00	119,053,060.60	213,439.40	99.8
Цэвэр, бохир ус	33,867,900.00	46,397,700.00	36,242,053.05	10,155,646.95	78.1
Хангамж, бараа материалын зардал	124,049,295.25	499,681,600.00	472,475,376.70	27,206,223.30	94.6
Бичиг хэргийн материал	27,824,934.65	75,000,000.00	74,299,472.91	700,527.09	99.1
Тээвэр, шатахууны зардал	8,300,000.00	24,000,000.00	15,098,564.00	8,901,436.00	62.9
Шуудан, холбооны зардал	36,708,622.00	56,000,000.00	55,897,263.77	102,736.23	99.8
Ном, хэвлэлийн зардал	16,371,408.60	160,000,000.00	152,803,563.00	7,196,437.00	95.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,657,990.00	19,681,600.00	13,025,000.00	6,656,600.00	66.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,186,340.00	165,000,000.00	161,351,513.02	3,648,486.98	97.8
Эд хогшил, урсгал засварын зардал	710,319,316.00	1,078,000,000.00	1,077,880,831.00	119,169.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	191,984,750.00	315,300,000.00	315,223,757.00	76,243.00	100.0
Тавилга, эд хогшил худалдан авах зардал	37,863,300.00	40,200,000.00	40,198,400.00	1,600.00	100.0
Урсгал зардал	480,471,266.00	722,500,000.00	722,458,674.00	41,326.00	100.0
Томилолт, зочны зардал	70,182,190.00	190,000,000.00	114,413,348.50	75,586,651.50	60.2

Удирдлагын академийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Гадаад албан томилолт	42,619,885.00	110,000,000.00	71,105,906.50	38,894,093.50	64.6
Дотоод албан томилолт	8,215,600.00	20,000,000.00	26,357,929.00	(6,357,929.00)	131.8
Зочин төлөөлөгч хүлээн авах	19,346,705.00	60,000,000.00	16,949,513.00	43,050,487.00	28.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	989,066,954.39	3,044,859,000.00	2,476,561,831.32	580,297,168.68	81.3
Эрдэм шинжилгээний ажлын зардал	976,515,703.39	3,000,528,000.00	2,420,332,949.03	580,195,050.97	80.7
Аудитын төлбөр	12,000,000.00	12,000,000.00	12,000,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	551,251.00	980,000.00	792,203.00	187,797.00	80.8
Даатгалын үйлчилгээ	-	261,000.00	260,820.00	180.00	99.9
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	42,600,000.00	42,523,709.82	76,290.18	99.8
Бусад үйлчилгээ	-	490,000.00	652,149.47	(162,149.47)	133.1
Бараа үйлчилгээний бусад зардал	3,705,187,171.81	2,394,712,800.00	2,456,222,004.41	-61,509,204.41	102.6
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,692,775,971.81	2,114,712,800.00	2,180,042,941.75	(65,330,141.75)	103.1
Бараа үйлчилгээний бусад зардал	12,411,200.00	280,000,000.00	276,179,062.66	3,820,937.34	98.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,514,380.00	2,353,327,000.00	205,790,598.87	2,147,536,401.13	8.7
Бусад урсгал шилжүүлэг	140,514,380.00	353,327,000.00	205,790,598.87	147,536,401.13	58.2
Тэтгэвэрт гарахад нэг удаагийн тусламж	41,823,000.00	183,936,000.00	91,614,698.87	92,321,301.13	49.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	98,691,380.00	126,391,000.00	71,288,300.00	55,102,700.00	56.4
Бусад тэтгэмж, урамшуулал	-	43,000,000.00	42,887,600.00	112,400.00	99.7
Хөрөнгийн зардал	552,154,094.00	2,000,000,000.00	-	2,000,000,000.00	-
Дотоод эх үүсвэрээр	552,154,094.00	2,000,000,000.00	-	2,000,000,000.00	-
Их засвар	552,154,094.00	2,000,000,000.00	-	2,000,000,000.00	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,587,391,845.19	16,891,553,200.00	12,057,998,359.70	4,833,554,840.30	71.4
Улсын төсвөөс санхүүжих	8,648,283,800.00	11,845,522,190.30	7,011,967,350.00	4,833,554,840.30	59.2
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,157,862,800.00	11,845,522,190.30	7,011,967,350.00	4,833,554,840.30	59.2
Бусад тусгай зориулалтын сангаас-ЗГ-ын нөөц сан	2,490,421,000.00	-	-	-	-
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	4,939,108,045.19	5,046,031,009.70	5,046,031,009.70	-	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,637,969,378.00	3,063,386,693.00	3,063,386,693.00	-	100.0

Удирдлагын академийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,024,210,725.79	1,871,230,446.70	1,871,230,446.70	-	100.0
Гадаад эх үүсвэрээс санхүүжих	276,703,111.40	111,413,870.00	111,413,870.00	-	100.0
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	11,224,760,727.87	-	14,104,889,683.83	-	-
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,104,889,683.83	-	12,609,312,609.22	-	-

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 2,128.5 сая төгрөгийн алдаа, зөрчил¹ илэрснээс 1,297.7 сая төгрөгийн алдааг² аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 14.1 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 444.7 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 228.0 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлага, 143.9 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 830.8 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 778.5 сая төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Аудитаар нийт 1,297.7 сая төгрөгийн алдаа³ илэрч, аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бичиг хэргийн материалын зарлагын нийт 230.0 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардлаар, хичээл үйлдвэрлэлийн дадлагын 711,258.5 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлаар ангилал буруу бүртгэж тайлагнасан;	1	711,488.5	-	-	1	711,488.5	1	711,488.5	-	-	-	-
Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх хөтөлбөр он дамжин хэрэгжиж 2023 оны үлдэгдэл 1,276,648.1 мянган төгрөгөөс 2024 онд хэрэгжсэн 934,752.0 мянган төгрөг, үлдэгдэл 341,896.1 мянган төгрөг байхаас 2,887.8 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн;	1	2,887.8	1	2,887.8	-	-	1	2,887.8	-	-	-	-
Тус академийн газраас нийтийн эзэмшлийн зам талбайд 498 м.кв талбайг хамруулсан газрын үнэлгээ 105,928.0 мянган төгрөгийг данснаас хасахдаа дахин үнэлгээний данснаас хассан;	1	105,928.0	-	-	1	105,928.0	1	105,928.0	-	-	-	-
Урьдчилж орсон орлого дансанд бүртгэлтэй 477.4 сая төгрөгийн сургалтын төлбөрийн орлогыг тайлант оны орлогод дутуу бүртгэсэн;	1	477,360.0	1	477,360.0	-	-	1	477,360.0	-	-	-	-
Дүн	4	1,297,664.3	2	480,247.8	2	817,416.5	4	1,297,664.3	-	-	-	-

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Удирдлагын академийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

3.2 Аудитаар нийт 830.8 сая төгрөгийн зөрчил⁴ илэрсэнд 14.1 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 444.7 сая төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 228.0 сая төгрөгийн хариуцлага тооцох 1 албан шаардлага, 143.9 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Академийн захирлын үндсэн цалинг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын 2020 оны 158 дугаар тушаалаар 2,695.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. 2023 онд эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр захирлын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэж, тус академийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Б/136 дугаар тушаалаар үндсэн цалинг 3,680.0 мянган төгрөгөөр тогтоосноос шалтгаалан 2024 онд нийт 12,960.0 мянган төгрөгөөр үндсэн цалинг нэмэгдүүлж олгосон байна.	1	12,960.0	-	-	1	12,960.0	-	-	-	-	-	-
Ажилчдад урамшуулал олгоходоо хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр буюу цалин хөлсний бүрэлдэхүүнээс /үндсэн цалин, ажилласан жил болон цол, зэргийн нэмэгдэлтэй/ тооцож, нийт 62,574.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	62,574.0	-	-	1	62,574.0	-	-	-	-	-	-
Цагийн ногдолгүй албан тушаалтан болох нэр бүхий 1 ажилтанд үндсэн ажлаас гадна сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил гүйцэтгэхдээ багшийн ажлын гүйцэтгэл тооцох журмаар тогтоосон хичээлийн нэг улиралд заах илүү цагийн хэмжээнээс 44.7 цагаар илүү бодож 965.5 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон байна.	1	965.5	1	965.5	-	-	-	-	-	-	-	-

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Удирдлагын академийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аж ахуйн нэгжээс хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар 8,550.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна.	1	8,550.0	1	8,550.0	-	-	-	-	-	-	-	-
Ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхээр 10 аж ахуйн нэгжээс 292,767.4 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ харьцуулалтын аргаас зайлсхийж, төсөвт өртгийг хэсэгчлэн хувааж шууд худалдан авалт хийсэн байна.	1	292,767.4	-	-	1	292,767.4	-	-	-	-	-	-
Жолоочийн шатахууны тооцоо бодоогүй, шатахууны үлдэгдлийг жолоочийн замын хуудастай тулган шалгаж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, бараа материалын тайланд тусгаагүй байна.	1	11,503.6	-	-	-	-	1	11,503.6	-	-	-	-
Тайлан онд 5 аж ахуйн нэгж, иргэнтэй 56,545.8 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ авах гэрээ байгуулж, гэрээ дүгнэж актаар баталгаажуулаагүй байна.	1	56,545.8	-	-	-	-	1	56,545.8	-	-	-	-
Хасу бизнес групп ХХК-тай гэрээ байгуулж 2024 оны 11-р сарын 06-ны өдөр импортоор оруулж ирсэн 2014 онд үйлдвэрлэгдсэн Toyota Vellfire маркийн суудлын автомашиныг 75,900.0 мянган төгрөгөөр худалдан авахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл аваагүй.	1	75,900.0	-	-	-	-	1	75,900.0	-	-	-	-
“Green ERP” програм хангамж нэвтрүүлэх зорилгоор “Дижитал воркс” компанитай 2021 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр УА/76 тоот гэрээг байгуулж, гэрээнд заасны дагуу програмын нэвтрүүлэлтийг бүрэн дуусгаагүй байхад орлогоор үртгэсэн, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгах өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.	1	228,000.0	-	-	-	-	-	-	1	228,000.0	-	-
Дүн	9	749,766.3	2	9,515.5	3	368,301.4	3	143,949.4	1	228,000.00	-	-
Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Аж ахуйн нэгж байгууллагаас бэлэг дурсгалд зориулан 21 ширхэг оёмол бүтээгдэхүүнийг 4,630.0	1	4,630.0	1	4,630.0	-	-	-	-	-	-	-	-

Удирдлагын академийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

мянган төгрөгөөр худалдан авч төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.												
Ажлын хэсэгт орж ажилласан тус академийн захирал болон 8 ажилтанд, нийт 33,558.4 мянган төгрөгийн ажлын хөлсийг ажилласан цаг болон ажлын гүйцэтгэл, үр дүнг нотлох баримтгүйгээр бодож олгосон байна.	1	33,558.4	-	-	1	33,558.4	-	-	-	-	-	-
Тус академи нь аяллын компаниар дамжуулан сургалтын төлбөрийн зардал гэж 167,659.4 мянган төгрөг зарцуулснаас гадаадын 6 сургагч багш болон 3 зөвлөх багшийн замын зардал, ажлын хөлсөнд 35,860.4 мянган төгрөгийг төлж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	35,860.4	-	-	1	35,860.4	-	-	-	-	-	-
Тус байгууллагын ерөнхий нягтлан бодогчийн хуулиар хүлээсэн үүрэг, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгтэй давхардуулан Ажил гүйцэтгэх гэрээгээр гэрээт нягтлан бодогч ажиллуулан 7,000.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.	1	7,000.0	-	-	1	7,000.0	-	-	-	-	-	-
Дүн	4	81,048.8	1	4,630.0	3	76,418.8	-	-	-	-	-	-
Нийт зөрчлийн дүн	13	830,815.1	3	14,145.5	6	444,720.2	3	143,949.4	1	228,000.00	-	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад нийцлийн асуудаар 3,290.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,223.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2696.7 сая төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									

Удирдлагын академийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Тайлант онд Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулах 175 мэдээллээс 5 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 34 гүйлгээний 1,446,088.4 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож, 22 гүйлгээний 1,250,634.0 мянган төгрөгийн гүйлгээг ил тод мэдээлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.	1	2,696,722.4	-	-	-	-	1	2,696,722.4
Дүн	1	2,696,722.4	-	-	-	-	1	2,696,722.4
Бусад нийцлийн асуудал								
“Улсаа урлахуй” шинжлэх ухаан, танин мэдэхүйн, баримтат уран сайхны киног 1,223,938.7 мянган төгрөгөөр хийлгэхээр шууд худалдан авалтын аргаар Мандала фильмс ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулж, нээлттэй сонгон шалгаруулалт явуулаагүй байна.	1	1,223,938.7	-	-	1	1,223,938.7	-	-
Дүн	1	1,223,938.7	-	-	1	1,223,938.7	-	-
Нийт	2	3,920,661.1	-	-	1	1,223,938.7	1	2,696,722.4